



## **“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016.02.05

№ ТУЗ2016001

Улаанбаатар хот

### **КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ДҮГНЭХ ТУХАЙ**

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 02 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.11 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны талаар гүйцэтгэх удирдлагын танилцуулсан тайланг хангалттай гэж үзсүгэй.

**ХОЁР.** Алтай зам ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан санхүүгийн тайланг үндэслэн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

**ГУРАВ.** Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг 2016 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуунд даалгасугай.

**ДӨРӨВ.** Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөсөн болон тогтоосон цаг хугацаанд үнэн зөвөөр тайлагнан, журмын дагуу НББ-д тусган ажиллахыг Алтайн зам ХК / Б.Энхбат, Э.Өлзийхутаг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



## **“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016.02.05

№ ТУЗ2016002

Улаанбаатар хот

### **НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ**

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 2 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1; 46.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтээр Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангаагүй байх тул 2016 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

**ХОЁР.** Тогтоолыг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.6 дахь заалтын дагуу 2016 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, тайлагнахыг ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



## “АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016.02.05

№ ТУЗ2016003

Улаанбаатар хот

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 02 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 60.1 дэх заалт, 76 дугаар зүйл, 76.1.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн 2016 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 сарын 04-ний Даваа гарагийн 16 цагт Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд хуралдуулахаар товлосугай.

**ХОЁР.** Хурлаар хэлэлцэх асуудал болон хуралдааны дэгийг Тогтоолын хавсралт №1-ээр батласугай.

**ГУРАВ.** Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Нямдавааг томилсугай.

**ДӨРӨВ.** Хурал зохион байгуулах болон тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй батласугай.

- |                   |   |
|-------------------|---|
| ➤ Комиссын дарга  | Б.Энхбат/ Алтайн зам ХК-ийн гүйцэтгэх захирал |
| ➤ Комиссын гишүүн | Т.Мөнгөнцацрал/ ТУЗНБД                        |
| ➤ Комиссын гишүүн | С.Баянмөнх/ ТУЗ-ийн гишүүн                    |

**ТАВ.** Хуралд оролцох эрхтэй, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2015 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгосугай.

**ЗУРГАА.** Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл өгөх, хавсралт №2-д заагдсан баримт бичигтэй танилцуулах ажлыг Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд 2016 оны 3 сарын 26-ны өдрөөс 2016 оны 3 сарын 30-ны өдрүүдэд 10:00-18:00 цагийн хооронд зохион байгуулахыг комисст даалгасугай.

**ДОЛОО.** Санал авах хуудасны загварыг тогтоолын хавсралт №3-д зааснаар батлаж, Хувьцаа эзэмшигчдийг эчнээ санал өгөх боломжоор хангах ажлыг зохион байгуулахыг ТУЗНБД Т.Мөнгөнцацралд үүрэг болгосугай.

**НАЙМ.** Эчнээ саналын хуудас хүлээн авах өдрийг тогтоолын тавдугаарт заасан өдөр эхлүүлж, 2015 оны 3 сарын 30-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

**ЕС.** Хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу түгээхийг ТУЗНБД Т.Мөнгөнцацралд даалгасугай.

**АРАВ.** Хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчид болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллахыг Комисст даалгасугай.

**АРВАН НЭГ.** Хуралтай холбоотойгоор гарах зардлыг Компаниас гаргахыг Алтайн зам ХК-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.НЯМДАВАА



## “АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016.02.05

№ ТУЗ2015004

Улаанбаатар хот

### САНХҮҮГИЙН АУДИТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 02 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Аудитын хорооны саналыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.10; мөн хуулийн 81 дүгээр зүйл, 81.4.3 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос санал болгосон хөндлөнгийн аудитын байгууллагуудаас Тэгш Сан Аудит ХХК-ийг 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэхээр сонгосугай.

**ХОЁР.** Тэгш Сан Аудит ХХК-тай гэрээ байгуулан ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Энхбатад зөвшөөрсүгэй.

**ГУРАВ.** Гэрээний хэрэгжилт биелэлтэд хяналт тавин ажиллахыг Аудитын хороонд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



## “АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.04

№ ТУЗ2016005

Улаанбаатар хот

### ТУЗ-ИЙН ДЭД ХОРООДЫГ БАЙГУУЛАН ДАРГА, ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 4 сарын 4-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйл, 78.1 дэх заалт, 79 дүгээр зүйл, 81 дүгээр зүйл 81.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн ХЭ2016003 тоот тогтоолыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн ТУЗ нь дэргэдээ дараахи хороодтой байхаар тогтоосугай..

- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Цалин урамшууллын хороо

**ХОЁР.** Дэд хороодын дарга болон гишүүдийг дараахи бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Аудитын хорооны дарга	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Мөнгөнцацрал
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнх
- Нэр дэвшүүлэх хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуун
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Балжинням
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Сономжамц
- Цалин, урамшууллын хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн Ц.Ганцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй

**ГУРАВ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар гишүүдийн дийлэнх олонхийн саналыг авсан М.Нямдавааг улируулан сонгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА